



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 02 ны өдөр

Дугаар А/07

Эрдэнэт

Мөнгөн тэтгэмж олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дах заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 4 дэх зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дах заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/531/136 дугаар тушаал, Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 1А/4616 тоот албан бичгийг тус тус үндэслэн тушаах нь:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дах заалтын дагуу хөдөө орон нутагт тогвор сууршилтай ажилласан албан хаагчдад төрөөс олгох мөнгөн тэтгэмж авах эмнэлгийн мэргэжилтнүүдийн нэрс, авах тэтгэмжийн мөнгөн дүнг хавсралтаар баталсугай

2. Хавсралтанд заагдсан нэрсийн дагуу мөнгөн тэтгэмжийг холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, батлагдсан төсөв болох хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 368.667.200 /Гурван зуун жаран найман сая зургаан зуун жаран долоон мянга хоёр зуу/-н төгрөгийг олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга / С.Мөнхзул /-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ